

# Living the Lotus 7

Buddhism in Everyday Life

2024  
VOL. 226



## РКК Пномпень салбар



### Living the Lotus Vol. 226 (2024.07)

Ахлах редактор: Акагава Кэйичи  
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Т.Оюу-Эрдэнэ  
Эхийг хянасан: Ш.Зоригмаа  
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс  
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,  
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan  
TEL: +81-3-5341-1124  
FAX: +81-3-5341-1224  
Email: living.the.lotus.rk-international@  
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

*Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.*

## Амьдрал ба “Мөнхийн амь”

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч  
Нивано Ничикоо



### Амьдрал бол буухиа уралдаан

Бурхны сургаалыг ойлгомжтойгоор түгээж ирсэн бурхны шашны Ринзай урсгалын ламтан Мацүбара Таидоо 88 насны ойгоороо дараах шүлгийг тэрлэсэн гэдэг:

“Наян хэдэн жил эхийнхээ гараас хөтлөн уулыг давж, усыг гатлан өнөөдөртэй золголоо.”

Тэрээр Үрабон ёслол дээр ном айлдах үеэрээ энэ шүлгийг танилцуулаад “Гялайлаа ээж ээ. Өнөөг хүртэл ийм эрүүл саруул амьдруулж байсанд гялайлаа.” хэмээн ээжийгээ дурсан санаж, талархсан сэтгэлээ байгаагаар нь илэрхийлсэн байдаг.

Ялангуяа Үрабоны улирал болохоор ийнхүү эцэг эхээ улам ихээр дурсан санаж суугаа нь ирэх жил тус шүлгийг тэрлэсэн ламтантай нас чацуу болох гэж буй би ганцаараа биш биз ээ.

Ламтны бичсэн номын дараах нэг хэсэг мөн сэтгэлд минь тод үлсэн билээ.

“Амьдрал гэдэг төгсгөлгүй буухиа уралдаан мэт зүйл. Хүн төрж үхнэ гэдэг нь хэдэн зуун сая жил үргэлжлэх амь насны буухиа уралдааны нэг гишүүн болон хичээнгүйлэн гүйж, дараагийн гишүүнд саваагаа дамжуулж буй хэрэг юм.” («Мацүбара Таидоогийн ном айлдсан он жилүүд» Коосэй хэвлэлийн газар)

Амьтай зүйл хэзээ нэгэн цагт үхэлтэй нүүр тулах нь дамжиггүй. Түүнчлэн хүмүүс бид амь нас барагдах тэр мөчийг “амьдралын төгсгөл” гээд бодчихдог. Гэвч Мацүбара ламтан амьдралыг “төгсгөлгүй буухиа уралдаан” гэж илэрхийлсэн байгаа юм.

Үхэл ирсэн ч тэр бол амь насны төгсгөл биш гэж ойлгож болохоор энэ нэг мөртөөс үгээр илэрхийлэхийн аргагүй тайвшралыг мэдэрнэ. Гүйх зай, хэрхэн гүйх нь харилцан адилгүй боловч хүн бүр агуу том амь насны үйл ажиллагааны нэгээхэн хэсгийг чадлаараа гүйх багийн нэг гишүүн ба амь нас тийнхүү мөнхөд нэгээс нөгөөд дамжсаар байдаг. Ингээд бодохоор сэтгэлд нэг л сайхан мэдрэмж төрнө.



## “Мөнхийн амь”-ыг үргэлжлүүлэх нь

Кёотоогийн их сургуулийн ерөнхийлөгч асан Хирасава Коо багш хэдэн зуун сая жил үргэлжлэх амь насны утга учрыг маш бодитоор илэрхийлсэн.

“Үхэл гэдэг нь агуу байгаль эхээс заяасан амь нас буцаад байгаль эх дээрээ очиж, эргээд байгаль эхийнхээ нэг хэсэг нь болж, дахин байгаль эхийн бүтээн байгуулалтад нэгдэх явдал. Энэ нь «байхгүй» болно гэсэн үг биш агуу байгаль дэлхийн шинэ бүтээн байгуулалтад оролцохоор явж байна гэсэн үг юм.” («Амьдаръя, өнөөдөр ч баяртайгаар», Чичи хэвлэлийн газар)

Энэ үгнээс үхэлтэй нүүр тулах уйтгар гуниг өчүүхэн ч үл мэдрэгдэнэ. Бүр эсрэгээрээ бидний амь үхлээр дамжуулан өнгөрснөөс ирээдүй рүү урсах их гол мөрөн мэт “төрсөн нутаг” руугаа буцаж, агуу байгаль дэлхийдээ эргэн ирж мөнх амьдрах юм байна гэсэн өргөн уудам төсөөлөл бууна.

Ихэнх хүн үхэл өөр дээр нь ирэхээр айн түгшиж, улам л сэтгэлээр унадаг. Энэ ертөнцөөс алга болно гэж бодохыг ч хүсэхгүй хүн байж ч мэдэх юм. Гэхдээ Шагжамүни бурхан хүн бүхнийг төрөх, өтлөх, өвдөх, үхэх зовлонгоос ангижруулахын төлөө туйлын үнэнийг эрэлхийлэх болсон гээд бодохоор үхлээс зугтах сэтгэл төрөх нь хэвийн зүйл болов уу. Шагжамүни бурхан эцэст нь хүмүүс бидэнд тийм зовлон шаналалыг давах арга зам болгон мөнх бусын сургаалаас авхуулаад туйлын үнэнд тулгуурласан дөрвөн үнэн, найман зөв зам мөрийн сургаалыг айлдсан. Өөрөөр хэлбэл ямар ч хүнийг аврах зовлонгийн талаарх ойлголт хийгээд практик дадлыг заан сургасан. Энэ талаар “Намуу цэцгийн үр” хэмээх домгоор олонд танигдсан нялх үрээ алдсан Киса Гооами бүсгүй ийнхүү өгүүлсэн байдаг: “Би найман дадлаас бүрдсэн эрхэм зам мөр, үхэшгүй мөнхрөх зам мөрийг хэрэгжүүлснээр бодитоор сэтгэлийн амар амгаланг олж, туйлын үнэнийг тольдон харсан билээ.”

Энд анхаарал татахуйц нэг үг байгаа нь “үхэшгүй мөнх” юм. Шагжамүни бурхан “Сутганипата” сударт бодь сэтгэлээ хөгжүүлэх хүн “үхэшгүй мөнхрөх үр шим”-ийг хүртдэг хэмээн айлдсан байдаг. Тэгвэл “үхэшгүй мөнх” гэдэг нь юу гэсэн үг юм бол? Бид хэзээ нэгэн цагт үхэлтэй нүүр тулахаас хойш өдөр тутмыг хэрхэн амар амгалан өнгөрүүлэх талаар бодож үзвэл зохилтой. Түүний нэг арга зам болгон дараа сарын дугаараар “үхэшгүй мөнх”-ийн талаар бага зэрэг эргэцүүлэн бодож үзэх болно.



# Рисшо Косей Кай байгууллага (Зурагт ном)

## Шинэхэн гишүүн танаа

### Бие биедээ туслах нь (тэдори)

Сургаал хичнээн гайхамшигтай ч гэлээ нийгэмлэгт элсэх төдийгөөр аз жаргалтай болдоггүй. Харин сургаалыг амьдралдаа хэрэгжүүлэх нь чухал. Тиймээс ахмад гишүүд шинэ гишүүдээ бурхны зам мөрд хөглөн, зааж сургадаг. Үүнийг “тэдори” гэж хэлдэг.

Шинэ гишүүд ахмад гишүүдээ даган тэдори

хийснээр олон зүйлийг сурч авдаг. Бусдын асуусан асуултаас өөрийн ойлгоогүй зүйлийг анзаарч суралцана.

Мөн уулзаж буй хүмүүсийнхээ дүр төрхийг харж, бодлыг сонсох нь бидэнд өөрийнхөө талаар тунгаан бодох боломжийг өгдөг.



#### Бяцхан мэдлэг

Рисшо Косей Кай нийгэмлэгийн гишүүн болсноор шууд сургаал түгээгч болдог. Энэ нь та элссэн өдрөөсөө эхлэн хүмүүсийг баярлуулах, ахмад гишүүдийн зааж сургасан зүйлийг бусдад дамжуулах үүрэгтэй болно гэсэн үг юм. Ахмад гишүүдтэйгээ хамт “тэдори хэмээх бурхны үйл”-ийг хийн хамт яваад үзээрэй.

\* Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.



## Сургаал номд суралцаж, амьдралдаа хэрэгжүүлэх нь (хооза, номд суралцах)



“Хооза” бол нийгэмлэг, сүм хийд зэрэг газар тойрог болон суугаад бурхны сургаалд тулгуурласан харах өнцгийг бие биенээсээ суралцах үйл юм.

Рисшо Косей Кай нийгэмлэг хоозаг чухалд үздэг. Бурхан багшийн сургаалыг хэрэгжүүлж аз жаргалтай болсон хүмүүс нь туршлагаа ярьж, зовлон бэрхшээлтэй хүмүүс нь сургаал сонсох боломжтой газар учраас тэр.

"Номд суралцах" гэдэг нь Бурхан багшийн сургаалыг сурахаас гадна өдөр тутмын амьдралдаа байнга мөрдөж, тунгаан бодох үйл болно.

Энэхүү “хооза” болон “номд суралцах” үйлийг давтан хийснээр хүнлэг мөн чанар сайжирдаг билээ.



### Бяцхан мэдлэг

Угтаа “хооза” гэдэг нь Шагжамүни бурхны суудаг суудал, ном айлдах хүний суудаг өндөр суудлыг хэлдэг байжээ. Бас сургаалыг номлодог газар болон цуглаан гэсэн утгатай байсан гэдэг.

## Цэцгийн булцууны амьдрах хүч

Акагава Кэйичи

Сайн байцгаана уу. Хагас жил нүд ирмэхийн зуур өнгөрч халуун зуны улирал Японд хэдийнэ иржээ.

Ингээд бид энэ сард “Мөнхийн амь нас” гэсэн айлдварыг хүлээн авлаа. Рисшо Косей Кай нийгэмлэгт “Мөнх үргэлжлэх амь” гэсэн илэрхийлэл байдаг.

Бид “Мөнхийн амь нас”-ыг залгамжлан үргэлжлүүлж байгаа учраас хүн бүр амь амьдралаа эрхэмлэн чухалчлах учиртай гэж боддог.

Өнгөрсөн жил нийгэмлэгийн гишүүн танилаасаа зуны цэцгийн булцуу авсан юм. Гэвч хадгалах нөхцөл муу байсан уу хатаж, би тэвдэн усанд дэвтээтэл бүр ч дордуулж хөгц ургачихсан байв. Дахиж сэргэхгүй байх гэж бодож байсан ч хавар ирэхийг хүлээж, гэрийнхээ цэцэрлэгт булцуугаа суулгалаа. Тэгээд тарьсанаа бараг мартчихсан байтал 5 сарын сүүлээр хоёр хөөрхөн навч гарч ирээд над руу инээмсэглэх нь тэр. Үхсэн гэж бодсон булцуу үнэхээр “амь”-тай байсан нь намайг гайхшруулсан юм. Түүний амьдрах эрч хүч миний сэтгэлийг маш их хөдөлгөсөн билээ.

Айлдвар дээр Нивано ерөнхийлөгч амьдралын буухиа уралдааны саваа үүрд мөнх нэгээс нөгөөд дамжсаар байх болно гэж хэлсэн.

Би ч гэсэн амьдралын их буухианы нэгээхэн хэсэгт гүйж яваа тамирчны хувиар энэхүү цэцгийн булцуу шиг хүчтэй амьдарч, хойч үедээ саваагаа итгэлтэйгээр хүлээлгэн өгөхийн төлөө шаргуу ажиллах болно.




Оклахома нийгэмлэгийн дарга асан Ясүко Хилдэбрэндийн гэрт зочилсон нь. (зүүн талаас Акагава дарга, Хилдэбрэнд дарга асан, Оклахома нийгэмлэгийн дарга Крис Ладсоу )  
2024 оны 3 сарын 19-ны өдөр

# Rissho Kosei-kai International

Make Every Encounter Matter



## A Global Buddhist Movement



Information about local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: [living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp](mailto:living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp)